



ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2014 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 242

Улаанбаатар хот

Тендерийн үнэлгээний хороо
байгуулах тухай

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Эдийн засгийн хөгжлийн сайдын 2014 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 71 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эдийн засгийн хөгжлийн сайдын 2014 оны төсвийн багцад тусгагдсан Улаанбаатар хотын Гурвалжингийн гүүрний баруун талд 10 кВ-ын хуваарилах байгууламж, 10 кВ-ын кабель шугам 2*630 кВА дэд станцын хамт шинээр барих зураг төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулах үнэлгээний хороог дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:

Л.Ганхуяг -Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хэлтсийн дарга

Гишүүд:

Х.Самбалхүндэв -Санхүү, хөрөнгө оруулалтын газрын газрын ахлах мэргэжилтэн
И.Лувсанцэрэн -Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын газрын мэргэжилтэн
Э.Энхтайван -Эрчим хүчний хөгжлийн төвийн хэлтсийн дарга
Ж.Ханд-Иш -Эрчим хүчний Ассоциацийн гишүүн
Б.Өрнөхбаяр -Эрчим хүчний Ассоциацийн гишүүн

Үнэлгээний хорооны гишүүн бөгөөд нарийн бичиг:

Ш.Шижирбат -Эрчим хүчний хөгжлийн төвийн цахилгаан тоноглолын хяналтын ахлах инженер

2.Тендерийн сонгон шалгаруулалтыг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж, тендерийн үнэлгээний дүгнэлт шийдвэр гаргаж танилцуулахыг Үнэлгээний хорооны дарга /Л.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
Д.ДЭЛГЭРЦОГТ